

ARLINGTON PUBLIC SCHOOLS

СУРГАЛТЫН АЛБА

Хүндэт эцэг эхчүүдээ,

Хэл яриа, бичгийн шалгалтыг(ХЯБШ 1-3) таны хүүхдээс авсан.

ХЯБШ 1-2 нь Виржиниагийн хамтын нийгэмлэгээс авдаг албан бус шалгалт юм. Энэ нь ангийн хичээл төлөвлөлтийн мэдээллээр багш нарыг хангах зорилготой. ХЯБШ шалгалт нь бүх уншигчдад тохирсон хичээлийг төлөвлөх үнэлж баршгүй мэдээллээр багш нарыг хангадаг.

Тус шалгалт нь дуу авиа болон хэвлэмэл материалын мэдлэгтэй холбоотой хэд хэдэн даалгавраас бүрдэнэ. Тодруулбал сурагчдаас дараах даалгаврыг гүйцэтгэхийг шаардсан. Даалгавар бүр тухайн ангид тавих түвшинтэй ба сонгосон даалгавруудын оноонуудыг нэгтгэн **нийлбэр оноог** гаргана.

ХЯБШ 1-2 Даалгаврууд:

- **Үсэглэх чадвар** - Сурагчдаас онцгой дуудлага бүхий үгсийг үсэглэн хэлэхийг шаардана. Сурагчид зөв бичих арга барил эзэмшсэн, мөн тухайн үгсийг зөв бичсэн бол оноо авна. Энэ нь багш нарт сурагчдынхаа зөв бичгийн дүрмийн түвшинг тодорхойлох боломжийг олгодог.
- **Салангид үг таних** - Сурагчдаас тухайн түвшингийн үгийн жагсаалтаас үг уншихыг шаардана. Хэвлэсэн материалаас утга санааг олж авах чадвар нь түвшин тус бүрийн үгсийг шууд, зөв таних эсэхээс ихээхэн хамаардаг.
- **Үсгийн дуудлага** (зөвхөн нэгдүгээр анги) – Сурагчдаас /sh/ гэх мэт нэг авиагаар дуудагддаг хоёр үсэг бүхий гурван диграфаас авахуулаад 23 үсгийн дуудлагыг хэлэхийг шаардана.
- ХЯБШ 1-2 дээрх **бичвэр аман уншлагаар** аман уншлагын түвшинг тогтоодог. Сурагчид түвшин бүхий бичвэрийг уншаад, бичвэрийг ойлгосон эсэхийг асуусан асуултад хариулдаг. Энэ дэд сорил нь уншиж буй үгээ таних, түгдрэлгүй ярих (хүүхдийн унших, зөв ойлгох, илэрхийлэх чадвар) болон ойлгоцын талаарх мэдээллээр хангадаг.

ХЯБШ-н дүгнэлт дээрх аман уншлагын түвшин нь тухайн хүүхдийн ойлгон, уншиж чадах хамгийн өндөр түвшин юм. Гэхдээ энэ нь хүүхдийн бие даан унших түвшингийн хэмжүүр байх албагүй. ХЯБШ Аман уншлагын оноог тайлбарлахад болгоомжтой хандах хэрэгтэй. Багш сурагчийн үг таних чадвар, түгдрэлгүй унших болон хэд хэд ангилсан хэсгүүдийг ойлгож байгаа чадварыг харах болно. Үгсийг шууд уншиж таних (хэцүү үгсийг таних) чадвар нь уншиж ойлгоход *зайлшгүй боловч уншиж ойлгоход хүрэлцээтэй* биш юм.

Ойлгоход зөвхөн үг таних чадвараас гадна суурь мэдлэг, холболт, үгийн сан, унших стратеги ашиглах, сэдэл, дадлага, хэлний ерөнхий чадвар зэрэг олон хүчин зүйлс нөлөөлдөг. Сурагчид нас, сонирхол, сургалтын түвшиндээ тохирсон материалыг уншиж сурах болно.

Ерөнхий жишгийг дэд сорилуудын жишгийн хамт намар, хавар аль алинд нь тодорхойлдог. Ерөнхий жишгийг мөн нэгтгэсэн оноо гэж нэрлэдэг бөгөөд тус сурагчийн *хүрсэн байвал зохих түвшингээс доош эсвэл дээш түвшинд* байгаа эсэхийг заана. Дэд сорилын жишиг тухайн чадварт хамаарах гүйцэтгэлийн түвшинд заадаг. Багш нар уншиж бичих хичээлийг тохиромжтой арга хэлбэрээр заахдаа шалгалтаас гарсан мэдээллийг ашиглана. *Анхан шатны* жишгийг хангахгүй байгаа сурагчид ХЯБШ 1-2 дээр зааснаар тодорхой чадваруудыг хөгжүүлэх **нэмэлт** хичээлд суух болно.

Дэмжлэг үзүүлсэн танд баярлалаа.